



**ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНХУТАГ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/07

Баянхутаг сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Засгийн газрын 2001 оны 224-р тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг ЕБС-ийн сурагчдад зохион байгуулах, хорт хавдраас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд асаргаатай иргэдэд үзлэг хийх хөнгөвчлөх тусламжийн зөвөлгөө өгөх, ахмад настаны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд ажил зохион байгуулах, дэлхийн эмч нарын өдрийн хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулж ажиллахыг НЭМ-ийн мэргэжилтэн /Г.Халиун/-нд даалгасугай.

2. Тус ажлуудын хүрээнд томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах ажилд 208800 төгрөг, асаргаатай иргэдэд үзлэг зохион байгуулах ар гэрийхэнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээний зөвөлгөө өгөх ажлын хүрээнд 343800, ахмад настаны эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд 368150 төгрөг, дэлхийн эмч нарын өдрийг угтан ахмад эмчид хүндэтгэл үзүүлэх ажилд 282950 төгрөг нийт 1203700 /нэг сая хоёр зуун гурван мянга долоон зуу/ төгрөгийн зардлыг төсөл хөтөлбөр сан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Цэнд-Аюуш/-д зөвшөөрсүгэй.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ГАНЗОРИГ